

Танилцуулга

ТСС нь япон хэлний сургуулийн нийтлэг ойлголтонд өөрчлөлт хийсэн юм.

Өнөөг хүртэл япон хэлний сургууль нь өөрийн менежментийн асуудалд голлон анхаарал хандуулж байснаараа багшийн хичээл зүтгэл нь сургалтын үр дүнд нөлөөлөх боломжгүй байдлыг бий болгож байсан. Багш бидний хүсэл эрмэлзэл бодит байдлаас ихээхэн зөрүүтэй байдагт сэтгэл дундуур байсан бөгөөд энэхүү байдлыг эрс өөрчлөхгүй бол гадаад оюутанд зориулсан жинхэнэ япон хэлний сургууль гэж байж болохгүй юм гэсэн дүгнэлтэнд хүрч зөвхөн багшид тулгуурласан япон хэлний сургуулийг байгуулахаар зорьсон юм.

ТСС япон хэлний сургууль нь багш бидний олон жилийн япон хэлний сургалтыг сайжруулах гэсэн хичээл зүтгэл дээр тулгуурласан, ирээдүйд олох ашиг хөөсөн байдлыг халж, менежментийг багш өөрийн гараар хийх боломжыг бүрдүүлсэн сургууль юм.

ТСС нь жижиг ч гэсэн олон мөрөөдөл дүүрэн сургууль бөгөөд та бүхний суралцахыг хүссэн бүх зүйлээ манай сургуулиас заавал олох болно гэдэгт итгэлтэй байна. Багш нартайгаа тогтоосон элэгсэг дотно харилцаанаас японы соёл, япон хүний сэтгэлийг ойлгож, мэдэж аваарай.

Та бүхний цаашдын амьдралыг улам гэрэл гэгээтэй болгохын тулд ТСС хамаг бүхнээ дайчлан чармайх болно.

Токиогийн Мэй Гио Жу Их Сургуулийн захирал

KANO HIROYOSHI

ТСС Япон хэлний сургуулийн онцлог

1. Элэгсэг, дотно чадварлаг заах арга

ТСС нь гэр бүлийн орчин бүхий сургалтыг зайлшгүй болгосон, амьдралын бүхий л үйл явцтай холбоотой элэгсэг, дотно, чадварлаг заах арга барилаар хангана.

2. Өндөр чанартай сургалт, дэвшин суралцах нарийн арга барилыг зааж сургана.

Сургалт нь олон жилийн туршлагатай багш, оюутандаа тохируулан, элэгсэг, дотно, ойлгомжтой байдлаар заана. Алгасан суралцах болон улиран суралцах сургалтын системтэй, шаардлагатай бол давтан сургалт зохион байгуулдаг. Дэвшин суралцах заавар зөвлөгөөг хүн тус бүрт багш томилогдон сургууль сонголтоос эхлээд элсэн орох бичиг баримт бүрдүүлэх хүртэл нарийн зааварчилгааг өгдөг.

3. Оюутны байр

Сургуулийн ойрхон цэцэрлэгт хүрээлэнд оюутны байр байрладаг. Хүсвэл боломжын үнээр байрлах боломжтой.

4. Тухтай орчин

Сургууль маань чимээгүй орон сууцны хороололд байрладаг бөгөөд хичээл хийхэд ихээхэн тохиромжтой орчин бүрдсэн. Гэхдээ хотын төвийн Шинжүкү дүүрэг хүртэл 10 минут зарцуулна.

5. Ухаалаг менежмент

ТСС багш хүний нээсэн сургууль учраас хичээнгүй оюутныхаа төлөө сургалтын төлбөрийг харьцангуй хямдруулж, сургуулийн онцлог бүхий тэтгэлгийн системийг бүрдүүлсэн.

6. Хичээлээс гадуурхи сонирхолтой арга хэмжээ

Сургуулийн хэмжээнд жилдээ 2 удаа автобусны тойрон аялал, улаан өндөгний баяр, төгсөлтийн аялал, ангиудын олон нийтийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, нийгэмтэй танилцуулж, оюутнуудын хамтын ажиллагаа, орон нутаг болон Япон улсын соёлын талаар мэдлэгтэй болоход тусалдаг.

Сургалтын агуулга

Сургалтын цагийн хуваарь: Даваа- Баасан гаригуудад

Үдээс өмнө 09:00-12:30

Үдээс хойш 13:00-16:30

хичээл	хугацаа	Сургалтын зорилго	Сургалтын агуулга	Сурах бичиг
Анхан шат	3 сар	Аж амьдрал хэрэглээний япон хэл Япон хэлний дуудлага сонсгол Япон хэлний хэл зүй, дүрэм Үйл үг, нэр үгийн хэрэглээний үндэс	Хирагана, Катакана, дуудлага, сонсох Хялбар өгүүлбэр	みんなの日本語 I
Анхан шат	3 сар	Үгийн баялагаа ашиглан үгүүлбэр зохиох Өдөр тутмын харилцан яриаг чөлөөтэй ярих	400 ханз Япон хэлний хэлзүй, дүрэм	みんなの日本語 II
Дунд шат	6 сар	Ярианы хэллэг, бичгийн хэллэгийн ялгаа Хүнд өгүүллэг зэргийг уншаад ойлгох /хэлний төвшин тогтоох шалгалтын 2 дугаар шат/	1000 ханз Япон хэлний хэлзүй, дүрэм, Ярианы дадлага	中級へ行こう 中級を学ぼう (中級前期)
Дунд шат	6 сар	Телевиз, сонинг ойлгох Өөрийн үзэл санааг чөлөөтэй илэрхийлэх Сэтгэлийн хоёрдмол санааг ойлгох /хэлний төвшин тогтоох шалгалтын 1 дүгээр шат/	2000 ханз Япон хэлний хэлзүй, дүрэм Ярианы дадлага Унших бичих	中級を学ぼう (中級中期) 学ぼう！にほんご (中上級)
Дээд шат	6 сар	Сонин сэтгүүлийг чөлөөтэй уншиж ойлгох Их сургуулийн лекцийг сонсоод ойлгох	Япон хэлний хэлзүй, дүрэм Ярианы дадлага Унших бичих Элсэлтийн шалгалтийн бэлтгэл	考える人上級読解 分野別学びの美の扉 Сонин, телевиз, жижиг өгүүллэг зэрэг материалыг ашиглана.

Элсэлтийн дүрэм, журам

Элсэлтийн нийтлэг шаардлага

1. Элсэгчдэд тавигдах шаардлага

- ① .Өөрийн нутагтаа 12 жилээс дээш боловсрол эзэмшсэн байх.
- ② Сүүлийн сургуулиа төгссөнөөс хойш 5 жил дотор байгаа хүн.
- ③ 150 цагаас илүү япон хэл үзсэн байх.
- ④ 1 сард элсэн орох хүсэлтэй хүмүүс япон хэлний төвшин тогтоох шалгалтын N4 дугаар зэргээс илүү түвшинд тэнцсэн байх.

2. Хичээлийн жил

4 сарын элсэгч хамгийн уртдаа 2 жил

7 сарын элсэгч 1 жил 9 сар

10 сарын элсэгч 1 жил 6 сар

1 сарын элсэгч 1 жил 3 сар

3. Хүсэлт гаргах хугацаа

4 сарын элсэгч 9 сарын 1–10 сарын сүүл хүртэл

7 сарын элсэгч 1 сарын 1 – 2 сарын сүүл хүртэл

10 сарын элсэгч 3 сарын 1 – 4 сарын сүүл хүртэл

1 сарын элсэгч 7 сарын 1 – 8 сарын сүүл хүртэл

4. Хүсэлт авах газар

ТСС Япон хэлний сургууль (TCC Japanese Institute)

〒165-0026 東京都中野区新井 5-28-4

(5-28-4, Arai, Nakano-Ku, Tokyo 154-0026, Japan)

5. Бүртгэлийн хураамж 20,000 иен

6. Сонгон шалгаруулалт: анкет шалгаруулалт, орон нутагт ярилцлага зэрэг

Хүсэлт гаргахад шаардлагатай бичиг баримт

/Хувь хүн/

1. Элсэн суралцах хүсэлт /сургуулиас гаргасан APPLICATION FORM байна./
2. Хувийн анкет, суралцах зорилгоо тодорхойлсон /сургуулиас гаргасан PERSONAL RECORDS байна./
3. Сүүлд төгссөн сургуулийн гэрчилгээ, диплом
4. Сүүлд төгссөн сургуулийн дүнгийн жагсаалт
5. Одоогийн эрхэлж байгаа ажлын тодорхойлт эсвэл сургуулийн тодорхойлт
6. 5 хувь зураг /3смХ4см сүүлийн 3 сарын дотор авахуулсан байх/
7. Япон хэлний түвшин тогтоох шалгалтын дүн болон J. TEST, NAT-TEST дүн /байгаа хүн нь/
8. Гадаад паспортын хуулбар

<Сургалтын төлбөр хариуцагч >

А. Тухайн оюутны гэр бүл болон хамаатан садангийн хүн нь сургалтын төлбөрийг төлөх тохиолдолд

1. Төлбөр хариуцагчийн нэр дээр байгаа дансны мөнгөн үлдэгдлийн тодорхойлолт 4 сард элсэгч нь /2 жил суралцах/ 2,200,000 иен
2. Одоогийн эрхлэж буй ажлын газрын тодорхойлолт
3. Орлогын тодорхойлолт эсвэл орлогын татвар төлсөн тодорхойлолт
4. Төлбөр хариуцах тухай батлан даалтын бичиг /сургуулиас гаргасан Oath for Payment of Expenses гэсэн маягт байна./
5. Төлбөр хариуцагч нь оюутантай ямар холбоотой эсэх тодорхойлолт

В. Япон дахь батлан даагч нь сургалтын төлбөрийг төлөх тохиолдолд

1. Оршин суугаа газрын тодорхойлолт
2. Ажлын газрын тодорхойлолт
3. Нийгмийн даатгалын болон орлогын татвар төлсөн баримт/жилийн орлогыг тодорхойлж чадах /

4. Зардал хариуцах тухай батлан даалтын бичиг/сургуулийн нэгдсэн маягт байна./

5. Хадгаламжийн үлдэгдэл тодорхойлсон банкны баримт

Японд суугаа батлан даагч төлбөр хариуцах бол элсэхийг хүсэгчийн хамаатан садан, компанийн харилцагч зэрэг ойрхон харилцаа холбоотон байх ёстой.

Сургалтын төлбөр

Элсэн орохдоо:

Элсэлтийн төлбөр	60,000 иен
Сургалтын төлбөр /1 жил/	630,000 иен
Сургалтын төхөөрөмж, хэрэгслийн зардал	55,000 иен
Даатгал /2 жил/	8,580 иен
Нийт	753,580 иен

*Хэрвээ өргөдөл гаргах үед бүртгэлийн хураамжыг эхлэж төлөх бол нийт 773,580 иен болно.

* 2 дахь жилийн сургалтын төлбөр/хагас жилийн 315,000 иен, сургалтын материалын үнэ 13,200 иен /-ийг 1 жилийн дараа виз сунгагдсаны дараа төлөгдөнө.

Төлбөр төлөх данс: Beneficiary`s bank: MiUFG Bank

Nakano Ekimae Branch, account number:1354646

Beneficiary: T C C 日本語学校 (TCC Japanese Institute)

***нэгэнт шилжүүлэг хийгдсэн төлбөрийг буцаан олгохгүй.**

Японд ирэх бэлтгэл

1. Сургууль хил нэвтрэх товчооноос шалгалтанд тэнцэгчийн мэдээллийг аваад өөрт нь шууд мэдээлэх учраас элсэн орох үед шаардлагатай төлбөрийг заасан дансанд шилжүүлэх хэрэгтэй.
2. Сургууль элсэлтийн төлбөрийн шилжүүлгийг хүлээн авсны дараагаар гадаад оюутны оршин суух зөвшөөрөл болон элсэн суралцах зөвшөөрлийг явуулна.

3. Япон улсын элчин сайдын яаманд оршин суух зөвшөөрлөө мэдүүлж виз авна.
Гадаад паспортгүй бол өмнө нь заавал паспорт гаргуулах хэрэгтэй.
4. Японд ирэх өдрөө тогтоосны дараа сургууль руу яаралтай мэдэгдэх хэрэгтэй.
 - Паспортын хамгийн сүүлийн хуудсан дахь гарын үсэг хүсэлт гаргасан гарын үсэг 2 ялгаатай бол виз гарахгүй.

Оюутны дотуур байр

1. **Нөхцөл:** 2 оюутан нэг өрөөнд байрлана. / 2-оос илүү өрөөнд 3, 4 үүлээ байрлана./
2. **Байршил:** Сургуулиас алхаад орох хэмжээний зайтай.
3. **Төлбөр:** 1 сарын байрны төлбөр 28,000-42,000 иен / байршлаас шалтгаалан төлбөрийн хэмжээ өөр / Энд цахилгааны төлбөр ороогүй.
4. **Тоног төхөөрөмж:** хөргөгч, агааржуулагч, газын плитка, гал тогоо, ариун цэврийн өрөө гэх мэт、WiFi
5. **Оюутны байрны төлбөр:**
 - Анх ороход төлбөр 20,000 иен
 - Даатгал /оюутны байрны 1 сарын төлбөртэй тэнцэнэ./ Гарах үед буцааж олгоно.
 - нэг сарын байрны төлбөр
6. **Байранд ороход тавигдах шаардлага:**
 - Хамгийн багадаа 3 сараар байрлах.
 - Байранд орох үедээ өөрөө өрөөгөө сонгох боломжгүй.
 - Байранд орсны дараагаар сул өрөө байвал шилжин орох боломжтой.
 - Байрнаас гарахдаа нэг сарын өмнө мэдэгдсэн байх.
 - Гэнэт байрнаас гарах тохиолдолд барьцааны мөнгийг буцаан олгохгүй болно.